

Компанийн 2018 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

1. Компанийн нэр: Техник импорт ХК
2. Хаяг: Баянгол дүүрэг, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө-125
3. Утас: 70001830
4. Регистрийн дугаар: 2057239

1. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагааны талаар

Техник импорт ХК нь 2018 оны эхний хагас жилийн тайлант хугацаанд компанийн “Дүрэм”-ээр олгосон үйл ажиллагааны хүрээнд компанийн ХЭХ-аас баталсан “2018 оны ажлын төлөвлөгөө”-ний дагуу компанийн бизнес үйл ажиллагааг дараахь үндсэн чиглэлээр зохион байгуулж хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд:

1. “Хөтөл Цемент Шохой” ТӨХК-иас цемент болон цементийн түүхий эдийг компанидаа болон өөрийн охин компаниудад нийлүүлж харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүсийн захиалгаар худалдан борлуулах
2. ОХУ-аас импортолсон, ОУ-ын чанар, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн /хөргөгч, угаалгын машин, хөнгөн цагаан хийцийн гэр ахуйн сав, суулга, замын битум/-ийг худалдан борлуулах
3. БНХАУ-ын мотоциклийн үйлдвэрээс мотоцикл, мотоциклийн сэлбэг хэрэгслийг импортлон аймаг, хот, хөдөөд болон өөрийн компанийн нэрийн барааны дэлгүүрүүдээр худалдан борлуулах.
4. Өөрийн эзэмшлийн байрыг ажлын байрны зориулалтаар аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүмүүст түрээслүүлэх.

Компани нь 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1 270 897 665 төгрөгийн ашигтай ажиллалаа.

2. Компанийн удирдлага, зохион байгуулалтын талаар

Компани 2018 оны эхний хагас жилд Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх удирдлага, санхүүгийн алба, борлуулалтын алба, техникийн алба, харуул, аж ахуйн үйлчилгээний алба гэсэн бүтэцтэй, байнгын ажлын байрны 60 гаруй ажилтантай ажиллалаа.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

Техник импорт ХК нь “Дүрэм”-дээ “Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал



Тайлант хугацаанд 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2018 оны 04-р сарын 16-ны өдрийн 15 цагт компанийн “Хурлын танхим”-д хуралдаж дараахь асуудлуудыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж хэлэлцүүлсэн. Үүнд:

1. Компанийн 2017 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-аас гаргасан дүгнэлт
2. Компанийн 2017 оны ажлын тайлан
3. Компанийн 2018 оны ажлын төлөвлөгөө
4. 2018 оны ТУЗ-ын гишүүд, хороодыг сонгох

Уг хуралд саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98,85 % нь оролцсон ба хурлаар хэлэлцсэн асуудлуудын талаар хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсаар санал авахад хурлаас гарах шийдвэр, тогтоолын төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчид дэмжиж 100%-ийн саналаар баталж шийдвэрлэсэн.

“Компанийн тухай хууль”-д заасны дагуу 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаас компанийн “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-д нийцүүлэн ТУЗ-ын Нэр дэвшүүлэх хорооноос ирүүлсэн шаардлагыг хангасан 3 хүнийг 2018 оны ТУЗ-ын хараат бус гишүүнээр, 6 хүнийг ердийн гишүүнээр тус тус сонгож баталсан. ТУЗ-ын гишүүдээр сонгогдсон 9 хүн бүгд компанийн засаглалын сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан.

Төлөөлөн Удирдах Зөвлөл

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн удирдлагыг хэрэгжүүлэгч эрх барих байгууллага бөгөөд компанийн хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалж, тэднийг төлөөлж компанийн “Дүрэм” болон “ТУЗ-ын үйл ажиллагааны журам”-аар олгосон эрх, үүргийн хүрээнд компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан шийдвэр, тогтоолыг хэрэгжүүлэх, компанийн үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангах, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, компанийн удирдлагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн удирдах зөвлөл компанийн стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөг баталж, төлөвлөгөөний биелэлтийг компанийн Гүйцэтгэх удирдлагаас сар тутмын тайлангаар авч хянан, холбогдох үүрэг, чиглэлийг өгч ажиллаж байна. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дэргэдээ байнгын үйл ажиллагаатай Аудитын хороо, Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороотой бөгөөд Аудитын хорооны удирдлаган дор компанийн дотоод аудитын алба нь компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажлын тайлангаа сар тутам ТУЗ-ын Аудитын хороонд тайлагнаж ажиллаж байна.

★
Техник импорт
ХК
105723
1М 001
2018.04.16

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

Аудитын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Компанийн тухай хууль болон компанийн ТУЗ-ын үйл ажиллагааны журамд заасан эрх, үүргийн хэмжээнд компанийн нягтлан бодох бүртгэл, аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагналын үнэн зөв байдал, компанийн дотоод хяналт нягтлан бодох бүртгэлийн стандарт, холбогдох хууль, дүрэмд нийцсэн байдал, эрсдлийн удирдлагын бодлого, стратегийг тодорхойлох, эрсдэлийн удирдлагын болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, хараат бус аудитын байгууллагыг сонгох зэрэг үйл ажиллагаанд хяналт тавих замаар Төлөөлөн удирдах зөвлөлд хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэх нөхцөл, бололцоог бүрдүүлэхэд оршдог.

Нэр дэвшүүлэх хороо

ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх удирдлагад нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлох, сонгон шалгаруулах, ХЭХ-д шууд нэр дэвшүүлэх, ТУЗ-ын гишүүд болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршдог.

Цалин, урамшууллын хороо

ТУЗ-ийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны үндсэн чиглэл нь компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТУЗ-ын гишүүд, Гүйцэтгэх удирдлага, бусад эрх бүхий албан тушаалтнуудын цалин, урамшууллын талаар баримтлах бодлогыг батлах, түүний хэрэгжилтэнд хяналт тавих, цалин, урамшуулал олгох санал боловсруулах, компанид мөрдөж байгаа ажлын үр дүнтэй холбогдсон компанийн урамшууллын системийн зорилгыг тодорхойлж үр дүнг үнэлэх чиглэлээр ТУЗ-аас чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь туслахад оршдог.

Тайлант хугацаанд компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл компанийн тухай хууль болон төрийн холбогдох байгууллагаас баталсан журмын шаардлагад нийцүүлэн 2018 оны 03-р сарын 05-ны өдрийн хурлаараа 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай, 2018 оны 02 сарын 12-ны өдрийн хурлаараа 2017 оны ногдол ашиг олгох эсэх тухай, 2018 оны 05 сарын 23-ны өдрийн хурлаараа банкнаас зээл авах эрх олгох эсэх тухай асуудлын талаар тус тус хэлэлцэж гишүүдийн дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэж тогтоол гарган хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа.

Тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-иас ирүүлсэн зөвлөмж, мэдээллийн хуанлийн дагуу тогтоосон цаг хугацаанд нь компанийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын байгууллагын дүгнэлтийн хамт, 2017 оны ногдол ашиг тараах эсэх тухай болон 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн тухай ТУЗ-ын хурлын тогтоол, тэмдэглэл, Хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлсэн мэдэгдлийн дагуу 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж хурлаар хэлэлцсэн асуудлуудаар гаргасан шийдвэр, тогтоолуудыг бусад холбогдох

материалуудын хамт, 2018 оны жилийн үйл ажиллагааны тайлан, 2018 оны хагас жилийн санхүүгийн тайланг Хөрөнгийн бирж ХК, СЗХ-нд тус тус хүргүүлж олон нийтийг мэдээллээр хангах үүргээ биелүүлж ажиллалаа.

Санхүүгийн зохицуулах хорооноос компанийн 2018 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын материал нь “Компанийн тухай хууль”-ийн 69.1 дэхь заалт, холбогдох хууль тогтоомж, журмын шаардлагыг хангасан тул компанийн 2018 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр хуралдсан хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсон тухайгаа 2018 оны 07 сарын 16-ны өдрийн 9/3044 тоот албан бичгээр ирүүлсэн.

Санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр

Компани 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжид заасан хугацаанд гаргаж СЗХ-нд бүртгэлтэй, албан ёсны зөвшөөрөлтэй Алаг уул финанс ХХК-иар аудитын дүгнэлт хийлгэж СЗХ болон Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж тайлагнасан.

Компанийн Төлөөлөн Удирдах зөвлөлөөс 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлж батлуулсан.

Компани тайлант хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын, хувь хүний орлогын, үл хөдлөх эд хөрөнгийн, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог 2018 оны 1-р улирлын байдлаар болон хагас жилийн байдлаар тогтоосон хугацаанд нь гаргаж, хуульд заасан хугацаанд харилцагч дүүргийн санхүү, татвар, нийгмийн даатгалын байгууллагад өгч баталгаажуулж хууль тогтоомж, холбогдох журамд заасны дагуу компанийн хагас жилийн санхүүгийн тайланг СЗХ болон Хөрөнгийн бирж ХК-д хүргүүлж ажилласан.

Хувьцаа эзэмшигчдийн бүтцийн талаар

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-өөс 2018 оны 04 сарын 03-ны өдрөөр гаргаж ирүүлсэн “Техник импорт ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн судалгаа”-наас авч үзэхэд Техник импорт ХК-ийн нийт хувьцааны тоо 1 446 755 бөгөөд 460 хүн компанийн хувьцааг эзэмшиж байна.

Ногдол ашгийн талаар

Техник импорт ХК нь жил бүр Хувьцаа эзэмшигчдийн хуралдаа ногдол ашиг олгосон эсэх талаарх тайлан, ТУЗ-аас гаргасан ногдол ашгийн талаарх тогтоол, шийдвэрийг танилцуулж хэлэлцүүлж батлуулдаг.

Компаниас ногдол ашиг олгох эсэх талаар гаргасан ТУЗ-ын тогтоол, хурлын тэмдэглэлийг компанийн тухай хууль, холбогдох журамд заасан хугацаанд Хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлж ажилладаг.

Техник импорт ХК-ийн Төлөөлөн удирдах Зөвлөл нь 2018 оны 02-р сарын 12-ны өдрийн хурлаараа 2017 оны ногдол ашиг олгох эсэх асуудлын талаар хэлэлцэж 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ын Аудитын хорооноос гаргасан дүгнэлтийг үндэслэн 2017 оны ногдол ашиг олгохгүй байхаар шийдвэрлэсэн бөгөөд 2018 оны Хувьцаа эзэмшигчдийн хуралд ТУЗ-ын Аудитын дүгнэлтийн хамт уг ногдол ашгийн талаар гаргасан тогтоолыг танилцуулж батлуулсан.

Тайлан гаргасан:

Техник импорт ХК-ийн Гүйцэтгэх захирал



Д. Ганцэцэг